

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

- Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/03/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Говь-Алтай аймаг Алтай хот 2021 он	Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас:70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Бүжинханд Утас: 70484030 Цахим хаяг: Bujinkhandj@audit.gov.mn
-------------------------------------------------------------------------------------------------------------	-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НА	Нийцлийн аудит



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Ц.ЭРДЭНЭБАТ ТАНАА

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.15 № 108

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Ажилчдад цалин илүү олгосон, Засгийн газраас тогтоосон орон тооны хязгаарыг мөрдөж ажиллагаагүй, татварын тодорхойлолтоор өглөг, авлага зөрүүтэй, авлага, өглөгийг барагдуулаагүй, жолоочийн тооцоо, зарцуулалтын тайлангүй шатахуун зарцуулсан, худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг байршуулаагүй, үлдэх өртөгтэй автомашин акталсан, авто сэлбэгийн зардлыг үр ашиггүй зарцуулсан зэрэг материаллаг 274.3 сая төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалттай, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4 заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

07022308


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.ТҮВШИНБАЯР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөг/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	248,256,668.76	257,835,443.47
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3,143,040.00	0
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	3,143,040.00	0
31210	Төгрөг	3,143,040.00	0
31213	Арилжааны банк дахь харилцах	3,143,040.00	0
33	АВЛАГА	188,680,413.76	158,514,243.47
33500	Бусад авлага	188,680,413.76	158,514,243.47
33510	Байгууллагаас авах авлага	149,628,198.76	107,427,810.47
33520	Хувь хүмүүсээс авах авлага	39,052,215.00	51,086,433.00
34	УРЬДЧИЛГАА	2,147,975.00	0
34710	Урьдчилгаа тооцоо	2,147,975.00	0
34713	Цалингийн урьдчилгаа	2,147,975.00	0
35	БАРАА МАТЕРИАЛ	54,285,240.00	99,321,200.00
35100	Түүхий эд материал	27,206,440.00	0
35110	Тусгай зориулалттай материал	27,206,440.00	0
35400	Хангамжийн материал	27,078,800.00	99,321,200.00
35410	Бичиг хэргийн материал	854,000.00	2,732,500.00
35420	Аж ахуйн материал	26,004,800.00	96,588,700.00
35430	Сэлбэг хэрэгсэл	220,000.00	0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,308,591,831.81	2,252,564,807.79
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,308,591,831.81	2,252,564,807.79
39100	Газар	0	0
39200	Биет хөрөнгө	2,218,762,853.69	2,162,955,945.19
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,056,496,583.05	2,056,496,583.05
39202	Хуримтлагдсан элэгдэл	-147,747,943.68	-182,022,886.68
39203	Авто-тээврийн хэрэгсэл	620,280,900.00	361,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-421,471,177.83	-206,452,777.85
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	372,746,824.48	395,261,329.85
39206	Хуримтлагдсан элэгдэл	-312,507,936.99	-299,698,173.36
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	252,659,444.23	222,027,119.56
39208	Хуримтлагдсан элэгдэл	-221,130,506.21	-201,014,415.98
39214	Бусад үндсэн хөрөнгө	32,111,073.00	32,111,073.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-12,674,406.36	-15,251,906.40
39300	Биет бус хөрөнгө	89,828,978.12	89,608,862.60
39301	Програм хангамж	78,153,755.00	78,153,755.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-76,924,776.88	-77,144,892.40
39303	Бусад биет бус хөрөнгө	88,600,000.00	88,600,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,556,848,500.57	2,510,400,251.26
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	4,878,939.00	1,735,899.54
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,878,939.00	1,735,899.54
41300	Өглөг	4,878,939.00	1,735,899.54
41360	Бусад өглөг	4,878,939.00	1,735,899.54
41361	Байгууллагад төлөх өглөг	4,878,939.00	1,735,899.54
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,551,969,561.57	2,508,664,351.72
51	Засгийн газрын хувь оролцоо	2,551,969,561.57	2,508,664,351.72
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,462,089,412.49	1,462,089,412.49
51200	Хуримтлагдсан үр дүн	599,607,720.60	556,302,510.75
51210	Өмнөх үеийн үр дүн	873,808,366.73	599,607,720.60
51220	Тайлант үеийн үр дүн	-274,200,646.13	-43,305,209.85
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	0	0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	490,272,428.48	490,272,428.48
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,556,848,500.57	2,510,400,251.26

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөг/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,528,689,333.40	4,059,725,526.37
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	78,357,030.00	171,073,938.37
120	Нийтлэг татварын бус орлого	78,357,030.00	171,073,938.37
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	78,357,030.00	171,073,938.37
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	55,175,030.00	106,063,873.00
120004 5	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	23,182,000.00	65,010,065.37
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,450,332,303.40	3,888,651,588.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	983,212,903.40	611,378,888.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	903,450,141.20	495,761,313.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	15,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	74,137,777.00	88,681,548.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	624,985.20	11,936,027.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,467,119,400.00	3,277,272,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,467,119,400.00	3,277,272,700.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,802,889,979.53	4,066,686,953.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,802,889,979.53	4,066,686,953.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,616,644,508.13	3,489,226,262.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,087,905,282.80	1,157,320,120.25
210101	Үндсэн цалин	551,560,063.53	703,825,180.68
210102	Нэмэгдэл	78,454,449.66	0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	49,082,150.61	108,829,110.57
210104	Урамшуулал	39,716,346.00	0
210105	Гэрээт ажлын хөлс	369,092,273.00	344,665,829.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	135,617,932.00	139,995,635.77
210201	Тэтгэврийн даатгал	95,355,010.00	130,824,635.77
210202	Тэтгэмжийн даатгал	16,263,725.00	0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,947,516.00	0
210204	Ажилгүйдлийн даатгал	2,200,564.00	0
210205	Эрүүл мэндийн даатгал	18,851,117.00	9,171,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	224,456,547.00	233,819,955.00
210301	Гэрэл, цахилгаан	15,918,127.00	16,095,896.00
210302	Түлш, халаалт	199,985,282.00	210,063,021.00
210303	Цэвэр, бохир ус	8,553,138.00	7,661,038.00
2104	Хангамж, бараа материалын зардал	102,679,833.00	253,494,412.00
210401	Бичиг хэрэг	13,965,400.00	19,349,000.00
210402	Тээвэр, шатахуун	66,154,500.00	89,284,158.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,059,933.00	15,036,774.00
210404	Ном, хэвлэл	500,000.00	810,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,000,000.00	128,115,380.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,850,000.00	54,629,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0	217,500.00
210604	Урсгал засвар	20,850,000.00	54,412,200.00
2107	Томилолт, зочны зардал	25,127,400.00	6,672,000.00
210702	Дотоод албан томилолт	25,127,400.00	6,672,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,730,681,495.44	1,495,963,452.64
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,717,786,395.44	1,481,586,498.64
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,460,000.00	0
210803	Даатгалын үйлчилгээ	8,400,000.00	8,400,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	925,000.00	800,954.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	176,000.00	176,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,934,100.00	5,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	289,326,017.89	147,330,986.53
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	52,123,120.00	30,270,240.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,667,000.00	1,258,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	232,535,897.89	115,802,746.53
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	186,245,471.40	577,460,691.17
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,030,500.00	23,326,517.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0	13,401,517.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,030,500.00	9,925,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0	554,134,174.17
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0	554,134,174.17
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	174,214,971.40	0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	169,663,191.20	0
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	4,551,780.20	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-274,200,646.13	-6,961,426.99
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0	36,343,782.86
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0	36,343,782.86
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-274,200,646.13	-43,305,209.85

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,462,089,412.49	490,272,428.48	873,808,366.73	2,826,170,207.70
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,462,089,412.49	490,272,428.48	873,808,366.73	2,826,170,207.70
9	Тайлант үеийн үр дүн	0	0	-274,200,646.13	-274,200,646.13
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,462,089,412.49	490,272,428.48	599,607,720.60	2,551,969,561.57
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,462,089,412.49	490,272,428.48	599,607,720.60	2,551,969,561.57
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,462,089,412.49	490,272,428.48	599,607,720.60	2,551,969,561.57
19	Тайлант үеийн үр дүн	0	0	-43,305,209.85	-43,305,209.85
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,462,089,412.49	490,272,428.48	556,302,510.75	2,508,664,351.72

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөг/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,644,124,670.20	4,039,277,091.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	59,505,828.00	142,691,873.00
120	Нийтлэг татварын бус орлого	59,505,828.00	142,691,873.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	59,505,828.00	142,691,873.00
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	59,505,828.00	142,691,873.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,584,618,842.20	3,896,585,218.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,117,499,442.20	619,312,518.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	863,871,511.00	468,668,093.00

Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын Газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	74,137,777.00	88,681,548.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	45,109,187.20	11,936,027.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,467,119,400.00	3,277,272,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,467,119,400.00	3,277,272,700.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,622,497,140.20	4,009,225,691.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,622,497,140.20	4,009,225,691.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,401,224,818.80	3,419,730,781.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,106,255,253.80	1,150,766,348.46
210101	Үндсэн цалин	569,910,034.53	583,704,771.40
210102	Нэмэгдэл	78,454,449.66	169,066,818.35
210103	Унаа хоолны хөнгөлөлт	49,082,150.61	57,636,013.71
210104	Урамшуулал	39,716,346.00	0
210105	Гэрээт ажлын хөлс	369,092,273.00	340,358,745.00
210106	Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/	0	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	135,617,932.00	138,968,677.41
210201	Тэтгэврийн даатгал	95,355,010.00	111,136,280.00
210202	Тэтгэмжийн даатгал	12,888,725.00	8,784,986.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,322,516.00	1,236,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,200,564.00	309,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	18,851,117.00	17,501,411.41
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	224,456,547.00	233,819,955.00
210301	Гэрэл, цахилгаан	15,918,127.00	16,095,896.00
210302	Түлш, халаалт	199,985,282.00	210,063,021.00
210303	Цэвэр, бохир ус	8,553,138.00	7,661,038.00
2104	Хангамж, бараа материалын зардал	86,169,933.00	100,856,874.00
210401	Бичиг хэрэг	14,010,000.00	20,510,000.00
210402	Тээвэр, шатахуун	49,600,000.00	56,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,059,933.00	15,036,774.00
210404	Ном, хэвлэл	500,000.00	810,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,000,000.00	8,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,462,500.00	60,180,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,762,500.00	0
210604	Урсгал засвар	19,700,000.00	60,180,200.00
2107	Томилолт, зочны зардал	25,127,400.00	7,022,000.00
210702	Дотоод албан томилолт	25,127,400.00	7,022,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,740,520,133.00	1,669,230,136.96
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,727,625,033.00	1,654,853,182.96
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,460,000.00	0
210803	Даатгалын үйлчилгээ	8,400,000.00	8,400,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	925,000.00	800,954.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	176,000.00	176,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,934,100.00	5,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	61,615,120.00	58,886,590.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	56,948,120.00	57,006,590.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,667,000.00	1,880,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	221,272,321.40	589,494,909.17
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,030,500.00	35,360,735.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,030,500.00	15,325,935.00

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0	554,134,174.17
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0	554,134,174.17
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	209,241,821.40	0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	169,663,191.20	0
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	39,578,630.20	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	21,627,530.00	30,051,400.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	18,484,490.00	33,194,440.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	18,484,490.00	33,194,440.00
2200	Дотоод эх үүсвэрээр	18,484,490.00	33,194,440.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	18,484,490.00	33,194,440.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-18,484,490.00	-33,194,440.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	3,143,040.00	-3,143,040.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,143,040.00	0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,282,272,700.00	2,896,066,658.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,282,272,700.00	2,896,066,658.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,246,237,900.00	2,860,705,923.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,119,962,000.00	1,116,607,603.46
210101	Үндсэн цалин	813,762,000.00	583,704,771.40
210102	Нэмэгдэл	0	169,066,818.35
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	57,636,013.71
210105	Гэрээт ажлын хөлс	306,200,000.00	306,200,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	143,904,000.00	134,670,825.41
210201	Тэтгэврийн даатгал	106,800,000.00	106,838,428.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,276,000.00	8,784,986.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,420,800.00	1,236,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,855,200.00	309,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	18,552,000.00	17,501,411.41
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	235,100,000.00	233,819,955.00
210301	Гэрэл, цахилгаан	19,800,000.00	16,095,896.00
210302	Түлш, халаалт	204,800,000.00	210,063,021.00
210303	Цэвэр, бохир ус	10,500,000.00	7,661,038.00
2104	Хангамж, бараа материалын зардал	101,410,000.00	100,856,874.00
210401	Бичиг хэрэг	20,510,000.00	20,510,000.00
210402	Тээвэр, шатахуун	56,000,000.00	56,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,400,000.00	15,036,774.00
210404	Ном, хэвлэл	1,000,000.00	810,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,500,000.00	8,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	85,000,000.00	83,180,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	16,000,000.00	16,000,000.00
210602	Тавилга	7,000,000.00	7,000,000.00
210604	Урсгал засвар	62,000,000.00	60,180,200.00
2107	Томиллолт, зочны зардал	7,561,500.00	7,022,000.00
210702	Дотоод албан томиллолт	7,561,500.00	7,022,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,466,934,300.00	1,125,661,875.96
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,452,337,300.00	1,111,284,921.96
210803	Даатгалын үйлчилгээ	8,400,000.00	8,400,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	925,000.00	800,954.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	176,000.00	176,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,000,000.00	5,000,000.00
210807	Газрын төлбөр	96,000.00	0

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	86,366,100.00	58,886,590.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	84,366,100.00	57,006,590.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.00	1,880,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,034,800.00	35,360,735.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,034,800.00	35,360,735.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	20,034,800.00	20,034,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,000,000.00	15,325,935.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,282,272,700.00	3,419,964,573.00
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0	0
310001	Улсын төсвөөс санхүүжих	0	0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,277,272,700.00	3,277,272,700.00
320001	Орон нутгийн төсвөөс	3,277,272,700.00	3,277,272,700.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	5,000,000.00	142,691,873.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000,000.00	142,691,873.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	3,143,040.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөг/

Код	Үзүүлэлт	Тайлант оны
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	619,312,518.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	619,312,518.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	619,312,518.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	34,158,745.00
210105	Гэрээт ажлын хөлс	34,158,745.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	429,752.00
210201	Тэтгэврийн даатгал	4,297,852.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	553,762,701.00
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	27,093,220.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	619,312,518.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	619,312,518.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	468,660,693.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	50,026,850.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	88,681,548.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	11,936,027.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, татварын байгууллагатай тооцоо нийлж санхүүгийн тайланг бодитой үнэн зөв хөтлөхтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ж.Бүжинханд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Засаг Даргын Тамгын газар нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дугаар сарын 14-ны өдрийн 3/46 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газар нь аймгийнхаа эдийн засаг, нийгмийн хөгжлийн хангах стратегийг төлөвлөх, оновчтой бодлого боловсруулах, тэдгээрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулалт хийх, бодлогын хэрэгжилтийн явц байдалд хяналт шинжилгээ хийх, үр дүнг нь үнэлж дүгнэх, нутгийн захиргааны байгууллагыг мэргэжлийн удирдлагаар хангах, төрийн албаны стандартыг хангуулах, иргэдэд захиргааны үйлчилгээ үзүүлэх замаар аймгийнхаа хөгжилд хувь нэмэр оруулах байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт өөрчлөлт орсон байна.

Коронавируст халдварт /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг 2020 онд баталсан. Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн 9 арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг эрүүл мэнд, онцгой байдал, мэргэжлийн хяналт, гааль болон төрийн чиг үүргийн байгууллагаас бусад байгууллагад даалгасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг шинэчлэн тогтоожээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Санхүүгийн хяналт аудитын алба нь 2021 онд Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газрын санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансны хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийгээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говь-Алтай аймгийн Засаг Даргын Тамгын газар нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл

баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын дүн болох 917.6 сая төгрөгөөс 2 хувиар буюу 18.3 сая төгрөгөөр тогтоосон. Гүйцэтгэлийн шатанд 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардал 4,044.6 сая төгрөгөөс 2 хувиар буюу 80.8 сая төгрөгөөр тооцсон. АДБОУС 2320-н 13-д зааснаар санхүүгийн тайланд анхлан тогтоосноос бага материаллаг байдал зохистой тул гүйцэтгэлийн материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говь-Алтай аймгийн Засаг Даргын Тамгын газар нь 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1.8 хувиар буюу 46.4 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Авлага дансны эхний үлдэгдэл 188.7 сая төгрөг, тайлант онд 30.2 сая төгрөгөөр буурч оны эцэст 158.5 сая төгрөгийн авлага тайлагнасны 48.5 сая төгрөг нь Шүүхийн шийдвэрээр олгосон цалингийн нөхөн олговрын, 27.1 сая төгрөг нь нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлгийн, 0.2 сая төгрөг нь Нийгмийн даатгалын шимтгэлийн, 79.8 сая төгрөг нь өвс тэжээлийн, 2.9 сая төгрөг нь хувь хүмүүсээс авах авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 99.3 сая төгрөг болж 45.0 сая төгрөгөөр өссөн нь бичиг хэрэг, аж ахуйн материалын үлдэгдэл өссөнтэй холбоотой. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 362.8 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, үйл ажиллагаандаа 318.9 сая төгрөгийн материалыг зарцуулан, 0.9 сая төгрөгийн хөрөнгийг акталж оны эцэст 99.3 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,501.0 сая төгрөг болж 266.9 сая төгрөгөөр багассан. Төсвийн хөрөнгөөр 33.1 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэн, 74.0 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авчээ. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны шийдвэрээр 143.7 сая төгрөгийн хөрөнгийг акталж, 230.5 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн тайлант оны эцэст 3,234.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,508.7 сая төгрөг болж 43.3 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй. Тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 556.3 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,752.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 524.8 сая төгрөгөөр өсгөн 3,277.2 сая төгрөгөөр баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 3 арга хэмжээг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр 3,277.2 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Үндсэн данснаас гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 3,277.2 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 2,750.2 сая төгрөгийг зарцуулж 527.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,896.0 сая төгрөг буюу 88 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 3.3 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 9.2 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 1.3 сая төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 0.6 сая төгрөгөөр, эд хогшил урсгал засварын зардлыг 1.8 сая төгрөгөөр, томилолт зочны зардлыг 0.5 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 341.2 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар нийт 619.3 сая төгрөгийн орлого орсноос НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилт 459.9 сая төгрөгийн, Байгаль орчны яамнаас 10.0 сая төгрөг, Батлан хамгаалах яамнаас 1.0 сая төгрөг, Архивын гэрээт албан хаагчдын цалинд 27.5 сая төгрөг, Соёлын яамнаас 30.0 сая төгрөг, Сангийн яамнаас 15.0 сая төгрөг, Дэлхийн байгаль хамгаалах сангаас 6.7 сая төгрөг, төрийн сангийн өмнөх оны төвлөрүүлсэн 35.0 сая төгрөг, төрийн албаны шалгалтаас 5.2 сая төгрөг, бусад 29.0 сая төгрөгийн орлого орсон байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилт, и-

баримтын бүрдэл, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 213 мэдээллээс 1 төрлийн 1.7 сая төгрөгийн өглөг, 11 төрлийн 142.1 сая төгрөгийн авлагын мөнгөн гүйлгээг мэдээлээгүй байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 И-баримттай холбоотой

Тус байгууллага нь тайлант онд аж ахуйн нэгж, байгууллагаас худалдан авалт хийхдээ И-баримтгүй 397.0 сая төгрөгийн гүйлгээ хийснээс аудитын явцад 262.6 сая төгрөгийн төлбөрийн баримтыг нөхөн шивүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т заасан заалттай нийцэхгүй байна.

3.9.3 Худалдан авах ажиллагаатай холбоотой

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу 56.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй шатахууны зардалд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т “Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна” гэсэн заалттай нийцээгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Аймгийн Засаг даргын тамгын газар нь 2018 оны санхүүгийн тайлангийн аудитын шийдвэрээс 24.5 сая төгрөгийн, 2019 оны санхүүгийн тайлангийн аудитын шийдвэрээс 7.4 сая төгрөгийн төлбөрийн актыг барагдуулаагүй байна.

2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар 3.0 сая төгрөгийн төлбөрийн акт, 444.6 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага, 625.8 сая төгрөгийн зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлж ажилласан байна. Үүнээс 170.9 сая төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар өглөг, авлагын бүртгэл, аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг үзэх нь зүйтэй. Гамшгийн сан болон аймгийн аюулгүйн нөөцийн өвс тэжээлийн авлага барагдуулалт, үнийн зөрүүг залруулсныг үзэх, мөн Шүүхийн шийдвэрээр олгосон цалин

олговортой холбоотой төсөвт үүссэн хохирлыг хэрхэн барагдуулах ажил зохион байгуулсан талаар үзэх хэрэгтэй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 976.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 512.1 сая төгрөгийн алдааг залруулж, 2.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 424.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэн, Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчилд зөвлөмж өглөө. Мөн Үндэсний аудитын газарт 37.3 сая төгрөгийн зөрчлийн асуудлыг уламжлахаар боллоо.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай холбоотой 249.5 сая төгрөгийн залруулга хийгдсэн. Иргэн аж ахуйн нэгж байгууллагаас худалдан авалтын 262.6 сая төгрөгийн и баримтыг нөхөн шивүүллээ.

4.2 Төлбөрийн акт

Амралтаа биеэр эдлээгүй ажилчдад олгох урамшууллыг 2.7 сая төгрөгөөр илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно." 61.1.9-т "ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй төрийн захиргааны албан хаагчид түүний зөвшөөрснөөр 1.5 сарын албан тушаалын цалинтай тэнцэх мөнгөн урамшуулал олгох" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

4.3 Албан шаардлага

ЗГ-аас тогтоосон орон тооны хязгаарыг мөрдөлгүй гэрээт ажилтан 17, үндсэн ажилтан 3 илүү ажиллуулсан нь Монгол улсын Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн "Аймгийн Засаг даргын тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай" 377 дугаар тогтоолын 3-т "Орон нутгийн онцлог, нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тоо, эдийн засаг, үйлдвэрлэлийн цар хүрээнээс хамааруулан Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Завхан, Орхон, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрыг 46 хүртэл, Булган, Говь-Алтай, Дундговь, Өмнөговь, Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газрыг 42 хүртэл, Говь-сүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газрыг 34 хүртэл орон тоотой байхаар тус тус тогтоосугай" гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Нягтлан бодогчийн цалингийн зэрэглэлийг зөрүүтэй тогтоож ТЗ-5-р цалинжуулж байгаа нь Засгийн газрын 2019 оны 276 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт "Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын зэрэглэл", Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн "Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай" Б/36 дугаар тушаалтай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Удирдлагын буруутай шийдвэрийн улмаас цалингийн нөхөн олговорт 12.0 сая төгрөгийг төлж төсөв хохироосон нь Захиргааны ерөнхий хуулийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ.", Хөдөлмөрийн тухай хуулийн 132.1-т "Хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцдаа өөрийн буруугаас байгууллагад эд хөрөнгийн хохирол учруулсан ажилтанд сахилгын, захиргааны, эрүүгийн хариуцлага оногдуулсан эсэхийг харгалзахгүйгээр эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэнэ.", Төрийн албаны тухай хуулийн 50.1-т "Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ." заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Санхүүгийн тайлан дахь татварын өглөг, авлага нь Татварын тодорхойлолтоос 110.2 сая төгрөгөөр зөрүүтэй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасантай нийцээгүй, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Аймгийн Гамшгаас хамгаалах сангаас 2018 оноос хойш бэлтгэсэн аймгийн аюулгүй нөөцийн өвс, тэжээлийн тооцоо нийлж авлагыг бүрэн барагдуулаагүй, борлуулсан үнийн зөрүү, хорогдол 35.7 сая төгрөгийг авлагаас хасаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Дулааны цахилгаан станц, Цэргийн анги, Цэнгэлдэх хүрээлэн барихтай холбоотой газрыг аймгийн ЗДТГ-т эзэмшүүлснээр газрын төлбөр ногдуулан 28.8 сая төгрөгийн өр үүссэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу 56.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй шатахууны зардалд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно." гэж заасантай нийцээгүй,

нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Шатахууны зардлаас 40.8 сая төгрөгийн шатахууныг зарцуулалтын тайлангүй, жолоочийн тооцоо бодолгүйгээр шууд зардлаар тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7-т "тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах" гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Тайлант оны эцэст НҮБ-ын Хүүхдийн сангаас шилжүүлсэн шатахууны 541.1 сая төгрөгийн үлдэгдэл Шатахуун түгээх станцад байгаа боловч шууд зардлаар тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Аж ахуйн нэгж, байгууллагаас 134.5 сая төгрөгийн и-баримтгүй худалдан авалт хийсэн нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ" гэж заасныг зөрчиж, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Засаг даргын нөөц хөрөнгөнөөс журам зөрчиж 6.1 сая төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах," Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралт "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 3.1.2-т "урьдчилан төлөвлөх боломжтой гадаад, дотоод албан томилолтын зардал, энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад зориулалтаар тоног төхөөрөмж бэлтгэх хөрөнгө оруулалтын зардлыг тусгаагүй байх," гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

4.4 Зөвлөмж

Аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 213 мэдээллээс 1 төрлийн 1.7 сая төгрөгийн өглөг, 11 төрлийн 142.1 сая төгрөгийн авлагын мөнгөн гүйлгээг өрийг бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр хэсэгт мэдээлээгүй байна.
- 1.2. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.4.8-т “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэсэн заалтыг мөрдөн ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4.5 Санал уламжлах

Тайлант онд Ланд-200 автомашинд төсвөөс 25.7 сая төгрөгийн сэлбэг хэрэгсэл зарцуулсан боловч аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 98 дугаар тогтоолоор эзэмшигчид нь 1.0 сая төгрөгөөр худалдсанаар төсвийн үр ашиггүй зарцуулалт бий болжээ.

ЗДТГ-ын 2020 оны төсвөөс 11.5 сая төгрөгийн Санато-7 маркийн автомашиныг худалдан авсан. Уг автомашин нь 8.6 төгрөгийн үлдэх өртөгтэй боловч аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 98 дугаар тогтоолоор эзэмшигчид нь 1.5 сая төгрөгөөр худалдсан.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-д заасны дагуу гэмт хэргийн шинж чанартай байж болзошгүй гэж үзээд Монгол улсын Ерөнхий аудиторт уламжилж байна.

2. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөг/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс									
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Уламжлах	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Говь-Алтай аймгийн Засаг Даргын Тамгын газар	16	976.8	1	512.1	1	2.7	11	424.7	1	0.0	2	37.3